



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

“Багануур” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааг бүртгэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Монголын хөрөнгийн бирж төрийн өмчит компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.5, 8.10.11, “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2, дах заалтууд болон “Багануур” хувьцаат компанийн 2016 оны 05 дугаар сарын 02-ний өдөр ирүүлсэн нэмж үнэт цаас бүртгүүлэх хүсэлтийн дагуу хийгдсэн шалгалтын тайланг үндэслэн тус тус тогтоох нь:

1. “Багануур” хувьцаат компанийн нийтэд санал болгон нэмж гаргаж байгаа нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 9,870,287 /Есөн сая найман зуун далан мянга хоёр зуун наян долоо/ ширхэг хувьцааг бүртгэж, тус компанийн нийт хувьцааны тоог 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 30,844,647 /Гучин сая найман зуун дөчин дөрвөн мянга, зургаан зуун дөчин долоо/ ширхэг байхаар бүртгэлд өөрчлөлт оруулсугай.
2. “Багануур” хувьцаат компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан тухай тушаалын хувийг Санхүүгийн Зохицуулах хороонд, холбогдох мэдэгдлийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанид хүргүүлэхийг Бүртгэл, судалгааны алба /Д.Тогтохбаяр/-нд үүрэг болгосугай.
3. Холбогдох мэдээлийн санд өөрчлөлт оруулахыг Хяналт, шалгалтын алба алба /Л.Нямдагва/-нд, “Багануур” хувьцаат компанитай “Бүртгэлийн гэрээ” шинээр байгуулахыг Хэрэг эрхлэх газар /Б.Батаа/-нд үүрэг болгосугай.
4. “Багануур” ХК-ийн нэмэлт хувьцааг Санхүүгийн зохицуулах Хороо бүртгэж, анхдагч болон хоёрдогч зах зээлийг эхлүүлэх зөвшөөрлийн дагуу үнэт цаасны арилжааг зохион байгуулахыг Арилжааны алба /Б.Чингүнжав/, Мэдээлэл технологийн алба /З.Батгэрэл/-нд үүрэг болгосугай.
5. “Багануур” хувьцаат компанийн үнэт цаасны танилцуулга болон үнэт цаас бүртгэгдэн, арилжихтай холбоотой мэдээллийг цахим хуудсанд байршуулж, олон нийтэд түгээн ажиллахыг Маркетинг, олон нийттэй харилцах алба /Ж.Мягмарсүрэн/-нд даалгасугай.
6. Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Багануур” хувьцаат компани /М.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.
7. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар /О.Отгонтөгс/-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР

ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ ХХК-д
ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ №396

Хэнд: “Үнэт цаасны
2016/05/....

Огноо:
хадгаламжийн төв” ХХК-д

ҮЗҮҮЛЭЛТ		ҮНЭТ ЦААС БҮРТГЭГДСЭН БАЙДАЛ	ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ОРОХ ӨӨРЧЛӨЛТ
Мэдэгдлийн агуулга:		Үнэт цаас хадгалуулах тухай	
Үндэслэл:		“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн № 193-тоот тушаал	
Санхүүгийн хэрэгсэл: /хувьцаа, өрийн хэрэгсэл гэх мэт/		Хувьцаа	Хувьцаа
Үнэт цаасны нэр:		“Багануур” ХК	“Багануур” ХК
Үнэт цаасны код: /үсгэн, тоон/		BAN /396/	BAN /396/
Үнэт цаасны төрөл: /энгийн, давуу эрхийн/		Энгийн	Энгийн
Үнэт цаасны хэлбэр: /биет, биет бус/		Биет бус	Биет бус
Нийт үнэт цаасны тоо: /ширхэг/		20,974,360	30,844,647
Энгийн	тоо /ширхэг/	20,974,360	30,844,647
	хувь /%/	100%	100%
Давуу эрхийн	тоо /ширхэг/	0	0
	хувь /%/	0%	0%
Төрийн эзэмшил	тоо /ширхэг/	15,730,770	15,730,770
	хувь /%/	75%	51%
Олон нийтийн Эзэмшил	тоо /ширхэг/	5,243,590	15,113,877
	хувь /%/	25%	49%
Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/		100	100
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/		2,097,436,000	3,084,464,700

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР